



Title	モンゴルの遊牧社会 : 1990年 : ゴビプロジェクトの調査資料をもとに
Author(s)	今岡, 良子
Citation	
Version Type	VoR
URL	https://doi.org/10.18910/103451
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

МОНГОЛЫН ХӨДӨӨ - 1990-ээд ОН: “Говь төсөл”-ийн судалгаанаас
харахад

ИМАОКА Рёоко
(Япон, Осакагийн Их Сургуулийн дэд профессор)

Би бол мэргэжлийн гэрэл зурагчин биш, Осакагийн Их Сургуульд монгол хэл ба нүүдлийн соёл заадаг багш хүн бөгөөд Монгол-Японы хамтарсан “Говь төсөл”-ийн судалгаагаар 1989 оноос одоо хүртэл Монголын хөдөө яваад хоносон айлынхаа гэр бүлийн зургийг аваад бэлэглэж ирсэн судлаач билээ. Баянхонгор аймгийн Богд сумын Зүүн Богд уулын Цэлгэр гэдэг баг нь дээр дурдсан төслийн суурин судалгааны газар юм. Тэнд амьдрагсдын дөрвөн үеийг хамарсан гэр бүлийн харилцааны гэрэл зургийг авчээ. Түүнчлэн өргөн хүрээний судалгаа хийж бүх аймгуудыг тойроод Богд суманд байхгүй зүйлсийн зургийг мөн авсан нь бий.

1990-ээд он бол Монголын судлаачдын хувьд хөдөө орон нутагт судалгаа хийхэд хүндрэлтэй байсан үе учраас гадаадын судлаач, тухайлбал бидний авсан гэрэл зураг, дүрс бичлэг, дуу бичлэгүүд үнэлж баршгүй хэрэгэлэгдэхүүн юм гэж МУИС, ШУТИС-ийн багш нар дүгнэсэн. Түүний нэг нь Ю.Болдбаатар багш намайг урьсанаар “МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ–90 ЖИЛ” гэдэг энэхүү олон улсын эрдэм шинжилгээнийн чухал хуралд орлцох болсон юм. Иймд, юуны өмнө Ю.Болдбаатар багш ба Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооныханд чин сэтгэлээсээ таралхал ирэлхийлж байна. МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙН ХӨГЖИЛ-д нь улам сайн

сайхныг хүсэн ерөөе!

1987 онд Монголын бүс нутгуудад “Перестройка - эдийн засгийн шинэчлэл” эхэлсэн бөгөөд намайг 1989 онд анх Монголд очиход эдгээр шинэчлэлийн үр нөлөө нь сум, нэгдэл бүрд өөр өөрөөр илэрч байсан юм. Учир нь малчид орон нутгийн байгалийн нөхцөлд тохируулан арга хэмжээ авч бас туршлага хуримтлуулан, бүс нутаг бүр хөгжлийн янз бүрийн хэв маягтай байв. 1988 онд “Төрийн аж ахуйн нэгжийн тухай хууль” батлагдаж, ХАА-н нэгдэл ба малчид хооронд “энгийн гэрээ”, “түрээсийн гэрээ” байгуулж эхэлсэн цаг үе. Харин 1989 онд ХАА-н нэгдэл малчдийн хувийн мал эзэмших хязгаарлалтыг цуцлан, малчид таван хошуу малаа өсгөж, “Хот айл” нөхөрлөлийг сэргээх санаа өрнөх болжээ. Ингээд малчин болгон санаа бодлоо илэрхийлэх болсон байна. Жишээ: “Уламжлалт улирлын нүүдэлдээ эргэн орж сум нэгдлийг дамнан их нүүдэл хийцгээе”, “Цагаан идээний баяр наадам зохион байгуулж, бүтээгдэхүүнээ чанаржуулцгаая!”, “Хөдөөнөөс шууд Улаанбаатар луу хувийн малын бүтээгдэхүүнээ тушаацгаая”, “Хилийн худалдаа хийцгээе”, “Би юу хийж чадах вэ?”, “Хамт олноороо өөр юу хийж чадах вэ?”, “Бид Нэгдэлээс юу хүсэх вэ?” гэх мэт малчид өөрсдөө нутгийнхаа ирээдүйг бодох болсон. 1990 онд Монгол Ардын Хувьсгалт Намын нэг намын ноёрхол дуусгавар болж анх удаа олон нам сонгуульд өрсөлдөв. Ингэснээр Нэгдлийн дарга болон АН-аас нэр дэвшсэн шинэ хүн хоёрын аль нэгийг сонгох боломж малчдад нээгдсэн юм. Мөн 1991 онд “Аж ахуйн нэгжийн тухай хууль”, “Төрийн өмчийг хувьчлах тухай хууль” батлагдаж ХАА-н нэгдлийн тогтолцоог задлах бэлтгэл ажил эхэлжээ. Ингэснээр 1992 онд ХАА-н нэгдлүүд татан буугдаж, хөрөнгийг нь шилжүүлж, нэгдлийн удирдлагуудыг

менежерээр нь ажиллуулан хувьцаат компаниуд байгуулсан юм. Гэвч тус хувьцаат компаниуд удалгүй ор сураггүй алга болжээ. Өнөөдөр хэдэн хүн тэр үеийн энгийн гэрээ, түрээсийн гэрээ тэгээд хувьцаат компанийн талаар мэддэг вэ?

Шашны үйл ажиллагаа явуулахыг хориглож байх тэр цаг үед Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэр хэмээх миний судалгааны суурин газарт 1987 онд Батцэнгэл гэдэг хэсгийн дарга удирдаж Зүүн Богд уулын орой дээр Овооны наадмыг сэргээсэн юм. Харин 1989 онд нэгдлийн дарга шимийн архи нэрэхийг хориглосон шийдвэр гаргахад малчид эсэргүүцэж улмаар 1990 оны сонгуулиар нэгдлийн даргаа биш харин Ардчилсан Намын нэр дэвшигчийг сонгоцгоосон байна. Улмаар 1992 онд малчид нэгдлээс гарцгааж хамтран Ардын аж ахуйтны хоршоо байгуулжээ. Хоршоо нь шинэ салбарын сургуулиа байгуулж, малынхаа ашиг шимийг гараар боловсруулж, ямааны ноолуурын фонд байгуулж, эмнэлэг барьж орон нутгаа хөгжүүлэхийн төлөө ажиллажээ. Мөн Баянхонгор аймгийн Баацагаан суманд малчин Сэмнээ мужаан, гагнуурчин, алт мөнгөний дархан, тракторын жолооч, малын эмч, оёдолчин зэрэг шинэ хамтлаг байгуулж, нэгдэл татан буугдсаны дараа байгуулагдсан хувьцаат компаниуд ч удаан үргэлжлэхгүй гэж таамаглаж, трактор, бусад техник хэрэгсэл татан буугдах үед хувьчлахыг хүлээж байв. “Сэмнээгийн хамтлаг” нь нүүдлийн амьдралтай байхдаа ч соёлтой амьдрахыг зорьж, малын ашиг шим боловсруулах үйлдвэр байгуулахаар бэлтгэж байв. Гэх мэт олон зүйлийг бид тэр үед авсан гэрэл зургаа хараад одоо тод дурсан санаж байна.

Энэхүү илтгэлдээ бид “Говь” төслийн судалгаанд үндэслэн гэрэл зургийн

хальснаа буулгасан өөрчлөлтүүдийг танилцуулж, бас малчдийн нүүр царай, өнгө үзэмж нь өнгөрсөн үеийнх шигээ харагдах боловч үнэндээ эдийн засгийн шинэчлэлийн давалгааг сайн ашиглаж, засаглалын өөрчлөлтийн энэ үеийн эмх замбараагүй байдлыг даван туулахын төлөө ажиллаж буй өөртөө итгэлтэй малчид байсныг харуулахыг зорьж байна.

Түлхүүр үг: *малчин, хөдөө, нэгдэл, хоршоо, 1990 он*



“ГОВЬ” төслийн хээрийн судалгаа (1989 он). Намайг юм тэмдэглэж авахад нутгийнхан “Энэ япон эмэгтэй монголоор бичиж байна” гээд дэвтэр лүү харж байлаа. Зарим малчин “Япон гэж орос царайтай хүмүүс байдаг байх гэж бодож байсан чинь бид нартай төстэй юм байна” гэж ярьж байв. Одоо ч гэсэн би хөдөө явахдаа энэ улаан хүрмээ өмсдөг.

(1.) ХАА-н нэгдлийн тогтолцоонд ажиллаж, амьдарч байсан малчид

(1.1) Сум-нэгдлийн төв



Сумын төв нь сумын тамгийн газар, хурал, ХАА-н нэгдэл гэсэн гурван байгууллага нэгдсэн засаг захиргааны төв байсан. Цэцэрлэг, 10 жилийн сургууль, дотуур байр, эмнэлэг, соёлын төв, агент, халуун ус гэх мэт байшин барилгатай. Арай зайдуу газарт ХАА-н нэгдлийн хашаа, агуулах, машин техник хадгалсан газар, клонк байх ба байгалийн үзэсгэлэнтэй газарт нэгдлийн гишүүний амралтын газар бий. Улаанбаатар луу хонь ямаа тууж явдаг тууварчид замдаа таарах тохиолдол байжээ.

Одоо сумын төвд 6, 7 дэлгүүр, 2, 3 зочид буудал, 2, 3 бензин клонк, 1, 2 банк, 1, 2 намын ажлын хэсэг, хэдэн хөшөө, фермертэй, арай зайтай газарт сүм хийд сэргээн баригдсан байдалтай.

(1.2) ХААн нэгдлийн хурал



ХАА-н нэгдлийн хуралд малчин гишүүн нар идэвхтэй оролцож, санаа хүслээ илэрхийлж нутгийнхаа мал аж ахуй ба нэгдлийг яаж хөгжүүлэх вэ гэж удаа дараа ярилцаж байжээ. Улсын бэлтгэл ба хувийн малын бүтээгдэхүүний тухай, энгийн гэрээ ба түрээсийн гэрээний ялгааны тухай, зудны үеийн хуучин хошуу нутаг дэвсгэрийн бэлчээрийн хэрэглээ ба нүүдлийн тухай, таван хошуу малтай болоод хот айл сэргэж говийн нутгийн 'ганц айл - ганц суурь'-ийн асуудлыг хэрхэн шийдэх тухай, эрлийз малын тэжээлийн өндөр зардлын тухай гэх мэт зүйлийг хэлэлцэж байв.

Одоо жилд 4 удаа зохион байгуулах багийн хурлаар зуны цагт өвөлжөөний бэлчээрийн нөөц хамгаалах асуудал чухал сэдэв болж байна.

(1.3) Агент



Япончууд бидний сонирхлыг татсан зүйл нь “агент” байсан юм. Худалдагч шууд бараа зарахгүй. Үйлчлүүлэгч эхлээд кассанд очоод мөнгөө өгч жижиг цаасанд барааны нэр, үнийг бичүүлээд тэр цаасаа худалдагчид өгөхөд лангуунаас тухайн барааг аваад “Май” гэж өгдөг байв. 1989 онд хөдөө сумын дэлгүүр ч гэсэн Орос, Герман, Чехословак, Румын зэрэг улсын чанартай бүтээгдэхүүнээр дүүрэн байсан. Ундааг бол шилтэй аваад хоосон шилийг буцаагаад өгнө.

Одоо хотын их дэлгүүрийн адил боловч жижиг хэмжээтэй хүнсний дэлгүүр 3, 4 байна. Хүнсний ногоо, өндөг, зайрмаг ч зарах болсон. Хятад ханзтай, Солонгос бичигтэй, Япон үсэгтэй цай, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг төрөл бүрийн бараа бий.

(1.4) Мал тооллого



Нэгдлийн малчин нь төрөл, хүйс, нас, тарга тэвээргээр нь нарийн ангилсан нэг төрлийн сүргийг хариулж байв. Жишээлбэл, малчин А бол 1 настай, эр, дунд зэргийн тарга хүчтэй хонины суурь хариулах үүрэгтэй. Жилийн дараа мал тоолох үед бүх нэгдлийн хонины амьдын жинг үздэг. Нийт хонины жин буюу нэг жилийн тарга хүч хэдэн кг авсан бэ гэдэг нь малчин А-гийн ажлын үр дүн болно. Түүний дараа 2 нас хүрсэн хонийг 2 настай эр хонийг хариулах малчин Б (сайн таргалсан), малчин В (дунд зэргийн таргатай), малчин Г (тарга хүч муу, зааз мал) гэж ялгаж өгөөд малчин А өөрөө дахиад 1 настай, эр, дунд тарга хүчтэй хонины суурь хариуцдаг байжээ. Ингээд малчдын дунд “Социалист уралдаан” тогтмол явуулдаг.

Одоо ч гэсэн мал тооллого явуулдаг боловч хувийн малын жинг үзэх шаардлагагүй, зөвхөн тоо бүртгэл хийх болсон.

(1.5) Сүүний тасаг - ферм



Зуны цагт нэгдлийн эмэгтэйчүүд нэг газарт цуглаж Сүүний тасаг гэдэг хамтлаг зохион байгуулаад нэгдлийн үнээ сааж, сүүгээ модон саванд хийгээд цөцгийн тос цохиж аваад, ялгаж үлдээсэн шингэн сүүгээр ааруул хийдэг байжээ. Цагаан сарын бууз бэлдэх шиг завгүй боловч хөгжилтэй харагддаг байлаа.

Одоо хувийн малтай болоод ферм байгуулаад гэр бүлийнхэн ба туслах малчинтайгаа хамтран сүү боловсруулж, цагаан идээ зардаг айл гарч ирж байна.

(1.6) ХАА-н нэгдлийн гишүүдийн амралтын газар



Манай Япон улсад ч ХАА-н нэгдэл байдаг. Гэвч тус нэгдлийн гишүүдэд зориулж барьсан амралтын газар бол байдаггүй. Харин малчин эмэгтэй хүүхэд төрүүлсний дараа энд амарч байгааг хараад БНМАУ-ын ХАА-н нэгдэл гэж ямар сайн систем вэ гэж гайхаж байлаа бид.

Одоо тэдгээр амралтын газар хаана байна вэ? ХАА-н нэгдлийг тараахад хувьчилсан уу ? Шинээр байгуулагдсан жуулчдын жижиг амралтын газар л хааяа нэг харагдаж байна. Ер нь малчдын амралтын өдөр гэж байгаа юм уу?

(2) Малчдын нийгмийн асуудал

(2.1) Усны асуудал : хэвээрээ



Ус бол амьдралын эх булаг юм. Ялангуяа малчдын ундны усны чанарын асуудал, усаа авах аргыг шийдэхийн төлөө социализмын үед дэд бүтэц сайжруулан олон тооны гүний худаг гаргасан байв. Бид харин цэвэрхэн цасаар чанасан цай уугаад ямар амттай юм бэ гэж гайхсан шүү.



© ГОВЬ ТӨСӨЛ



1990 оноос хойш хөдөө орон нутгийн амьдралын дэд бүтцийг сайжруулах талаар ямар нэг бодлого явуулсан шинж бид нарын судалгааны газарт харагдаагүй.

(2.2) Түлээ түлшний асуудал : хэвээрээ



Богд сумын Цэлгэр хэсэгт



© ГОВЬ ТӨСӨЛ



Модгүй говийн нутагт аргал, хоргол, заг, шаваг зэргийг түлдэг. Хоол хийх ба цай чанахын тулд өдөр бүр түлш хэрэгтэй. Өвлийн цагт гэрээ халаахын тулд, зуны цагт цагаан идээ боловсруулахын тулд түлш шатаах ба жилийн турш түлээ түлш хэрэглэдэг. Чанартай түлш хэрэглэж ургамлын нөөцийг хамгаалах ёстой боловч одоогоор аргал, хоргол, заг, шаваг түлдэг амьдрал нь хэвээрээ байна.

(2.3) Бензин шатахуун ба цахилгаанжуулалт



1991 оноос бараа бүтээгдэхүүний үнэ ба үйлчилгээний төлбөрийг чөлөөлснөөр зах зээл үнийг тодорхойлж эхэлсэн. Манай “Говь” төслийн судалгааны баг ч эхэн үедээ талон өгч бензин авч байсан.

Одоо сумын төвд хоёр гурван ч клонк ажиллах болсон байна. Гэвч энэ зун (2025.08 сар) бензин тээвэрлэгч машин замдаа осолдоод Богд сумын ойр орчмын гурван сум 7 хоног бензингүй байв. Ноолуурын үнэ өсөхийн хэрээр говийн бүсийн нүүдэлчид хэд хэдэн жийп машин, ачааны машин гэх мэт унаатай болсон бол Өмнөговь аймагт зарим нүүдэлчин чиргүүлтэй кемпер машинаа тансаг хүлээн авах өрөө болгон амьдарч байна.



© ГОВЬ ТӨСӨЛ



хонда,ямаха мотор

1989 онд говийн малчин айлд Хонда эсвэл Ямаха мотор ашиглаж байхыг олонтоо хардаг байсан ч бензин ховордож байсан тул заримдаа "төмрийн хог" болж байжээ. 1990-ээд оноос хойш Монголд үйлдвэрлэсэн зурагт, Хятадад үйлдвэрлэсэн нарны зай хураагуурыг говийн малчин ашиглаж, нүүдлийн амьдрал ахуйгаа сайжруулахын тулд шинэ цахилгаан хэрэгсэл, генераторыг амьдралдаа идэвхтэй нэвтрүүлж байв.

(3) 1990 оны Сонгууль - Ардчилал



Баянхонгор аймгийн төвд



Баянхонгор аймагт 1990 онд сонгуулийн санал авах байранд сонгогчид цэнхэр хөшигтэй өрөөнд саналын хуудсаа бөглөж, сонгуулийн ажилтнуудын урдах өмнө шар хайрцагт саналын хуудсаа хийж байсан юм. Баянхонгор аймгийн дотор ХАА-н нэгдлийн даргаа сонгоогүй цорын ганц сум нь Богд сум байлаа. 1989 онд архичин устгах талаарх Засгийн газрын бодлогын дагуу малчин айлын шимийн архи нэрдэг бүрхээрийг хураагаад архи нэрэхийг хориглосон юм. Иймд малчид гомдон эсэргүүцэж 1990 оны сонгуулиар уг нэгдлийн даргыг биш Ардчилсан намын нэр дэвшигчийг сонгосон билээ.

(4) Малчин ардын хөдөлгөөн

1988 онд “Төрийн аж ахуйн нэгжийн тухай хууль” батлагдаж, Нэгдэл ба малчин хооронд “энгийн гэрээ”, “түрээсийн гэрээ” байгуулж, 1989 онд малчдийн хувийн мал эзэмших хязгаарлалтыг цуцалж, малчид таван хошуу малаа өсгөж, “Хот айл” нөхөрлөлийг сэргээх санаа өрнөж байв. Нэгдлийн удирдлага ч зөвхөн нэгдлийн малын тоог нэмээд зогсохгүй малчдын нийгмийн асуудал, ялангуяа “ганц суурь-ганц айл”-ын асуудал шийдэхээр зорьж байв.

(4.1) “Ганц суурь”-аас “томсгосон суурь” луу

ганц суурь →

томсгосон суурь



Завхан аймаг Идэр, Алдархаан сум



Завхан аймгийн сумдад томсгосон суурь байгуулж байв. Нэгдэлтэй 7 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулж, ашгийн 70-80 хувийг хувь хүнд, 20-30 хувийг томсгосон суурийн хамтын фондод хуримтлуулахаар шийджээ. 8 айл бүхий 1 томсгосон суурь Улаанбаатарын зах руу малын бүтээгдэхүүн шууд нийлүүлэх болсон байна. Энэхүү томсгосон суурь:

1. Нэгдлийн гишүүдийн бүтээлч санаачлагыг үйлдвэрлэлтэй шууд холбох,
2. Олон төрлийн мал малласнаар мал аж ахуй эрхлэх сонирхолтой болох,
3. Хамтын хүчээр ажиллаж амьдрахад чөлөөтэй байх,
4. Нэгдлийн залуу гишүүдийг тогтоох, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлэх

гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Одоо энэ зургийг харахад нэг айлд олон хүүхэд байдаг нь харагдаж байна. Ингэж найман өрх цугларан нэг том бүлэг бүрдүүлж, гүүний үрс гаргах ёс, эсгий хийх хонины найр шиг уламжлалт зан үйлээ сэргээж, хувийн хонины ноосоо нийлүүлж хамтаараа эсгий хийх болцгоосон.

(4.2) “Ганц суурь”-аас “Сэмнээгийн хамтлаг”

Баянхонгор
аймгийн
Баацагаан
сумын
5-р хэсгийн
малчин
П.Сэмнээ



П.Сэмнээгийн¹ хамтлаг нь хоньчин 4 өрх, ямаачин 3 өрх, тэмээчин 1 өрх, мужаан 1 өрх, жолооч 1 өрх нийт 10 өрх байжээ. Сэмнээ ингэж хамтлаг байгуулан нэгдэлтэй түрээсийн гэрээ байгуулсан байна. Жишээлбэл, ингэ 25 толгойгоос 20 ботго төллүүлэх гэрээ байгуулж 25 ботго авбал 4 ботгыг эзэнд нь, 1 ботгыг хамтын санд нийлүүлэх зэргээр хамтын фондын мал 50 толгой, гахай 10 толгойтой болох юм. Энэ хөрөнгөөр хамтын гэр, машин худалдан авч нүүдэллэнгээ ч соёлын газартай байх гэсэн Сэмнээгийн бодол байлаа. Энэ нь Нэгдлийн нормоо биелүүлээгүй малчинд хамтын хүчээр тусалдаг, ялангуяа залуу малчдыг дэмжих сайн арга болжээ.

¹ Пүрэвийн Сэмнээ бол Монгол улсын арслан Э.Батмагнайн өвөө, БНМАУ-ын хошой аварга малчин юм.

ганц суурь → Сэмнээгийн хамтлага



Баянхонгор аймаг Баацагаан сум



© ГОВЬ ТӨСӨЛ

Сэмнээгийнхэн зөвхөн сумын дотор биш, өвөлжөө байдаг Баацагаан сумаас зуслан байдаг аймгийн төв хүртэл хуучин хошуу шиг хол нүүдэл хийдэг байжээ. Хувийн малын өмчлөл нэмэгдэхийн хэрээр аймгийн төвд байх зах руу ойртох хэрэгцээ улам бүр нэмэгдэв.

Сэмнээгийн хамтлагт мужаан, гагнуурчин, алт мөнгөний дархан, тракторын жолооч, малын эмч, оёдолчин гэх мэт мэргэжилтэй боловсон хүчин байсан. Сэмнээгийнхэн Баацагаан суманд гар урлалын үйлдвэр байгуулж, өөрсдийнхөө малын бүтээгдэхүүнийг боловсруулж, нэмүү өртөг шингээх, зах зээлд борлуулах, нүүдэлчдийн аж ахуй амьдралд шаардлагатай эд зүйлсийг үйлдвэрлэх чиглэлээр ажиллаж байжээ.



© ГОВЬ ТӨСӨЛ

Нэгдлийн өмч хувьчилахад Сэмнээгийнхэн хувь хувьдаа цөөн мал авах биш, хамтлагаараа том машин техник, агуулах авах санаатай байжээ. Гэвч Нэгдлийн том хөрөнгийг хувьчлалгүй харин нэгдэл татан буугдсаны дараа байгуулагдсан Хувьцаат компанид шилжүүлсэн байна. Сэмнээ “Хувьцаат компаниуд удаан үргэлжлэхгүй” гэж таамаглаж трактор болон бусад техник хэрэгслийг татан буугдах үед нь хувьчилж авахаар хүлээж байв.

(4.3) “Ганц суурь”-аас “Үүрийн туяа” ардын аж ахуйтны хооршоо →


Баянхонгор
аймгийн
Богд сумын
Цэлгэр хэсгийн
малчин
Б.Батцэнгэл



1984 онд Б.Батцэнгэл нь Цэлгэр хэсэгт хэсгийн даргаар иржээ. Тухайн үед уг хэсэг 26 малчин өрхтэй байв. Тэд 1987 оны зун ган болсонд овоогоо тахиж наадам хийсэн юм. Улмаар орон нутгийг хөгжүүлэх боловсон хүчин бэлдсээр 1991 онд Цэлгэр хэсгийн малчин өрхийн тоо 54 хүрчээ.


1990 оны сонгуулиар тэд нэгдлийн даргаа биш Ардчилсан намын нэр дэвшигчийг сонгосон юм. 1992 оны өвөл Б.Батцэнгэл нэгдлээс гарч хоршоо байгуулах бэлтгэл ажилдаа оржээ. Тэрээр малчин өрх бүрээр орж өөрсдийн амьдрал, үйлдвэрлэлээ хамгаалах, сайжруулахын тулд бие даасан ардын аж ахуйтны хоршоо байгуулцгаая хэмээн уриалсан байна. Хоршоо байгуулах

хурал хийсэн 12-р сарын 4-ний өдөр нь морь, тэмээ цантсан хүйтэн өдөр байсан ч Цэлгэрийн малчид эр эмгүй бүгд цугларчээ.



Хуралд оролцогчид халуун сүүтэй цай ууж, гурилтай шөл идэцгээн дулаацсаны дараа хоршооны зорилго, үйл ажиллагаа, санхүүгийн тухай ярилцсан байна.

Хоршоо үүтгэсний дараа тэд сургууль хүртэл байгуулж 1-4-р ангийн сурагчид гэрээсээ морь унаад сургуульдаа явж байв. Сургуулийн хажууд малынхаа ашиг шимийг боловсруулах эмэгтэйчүүдийн бүлгэм байгуулжээ. 4 багш ба 1 эмч сумын төвөөс шилжин ирэхэд хоршооноос 30 эм ямаа бэлэглэсэн байна. Малчид ноолуурын фонд байгуулж эмийн сангийн төсөв болгосон аж. Ингэж хоршооны гишүүн бүр орон нутгаа хөгжүүлэхийн төлөө ажиллацгааж байсан бөгөөд Цэлгэрийн малчин өрхийн тоо 110-д хүрэв.



Эх сурвалж: М.Онуки, К.Ито (1998).
Documentary film "Four Seasons Nomadism - from 1992 to 1993
at Tselger in Bogd county, Bayankhongor".

тэмээний тохош



©ГОВЬ ТӨСӨЛ

Эдийн засгийн шинэчлэл эхэлсэн 1987 оноос Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Булган, Өмнөговь аймагт малчдийн бие даасан эдийн засгийн үйл ажиллагаа, сум нэгдлийн хэсгийн хэмжээгээр төрсөн нутгийг хөгжүүлэх шинэ сорилтууд борооны дараах мөөг шиг гарч ирсэн.

Одоо бодоход 1990-д оны хөдөө бол

- социалист системийн сайн талыг хадгалсан,
- уламжлалт мал аж ахуйн сайн тал сэргэсэн,
- зах зээлийн нөлөөг ашигласан,
- өөрийн хэрэгцээнд тохирсон орчин үеийн шинжлэх ухаан ба технологийг сонгож эхэлсэн,

- Монголын малчин ардын хөдөлгөөн идэвхтэй, малчдын аж амьдрал гэгээтэй гялалзсан цаг байсан гэж хэлж болно.

Хөдөө орон нутагт өрхийн хэмжээний жижиг аж ахуй, томоохон хотуудын ойролцоо суурин мал аж ахуй, эрчимжүүлсэн ферм, капиталист бизнесийн менежменттэй аж ахуй ч бий. Малын тоо толгой нэмэгдэж, тэр дундаа ямааны ноолуурын үнэ өссөн. Мөн ноос, цагаан идээ боловсруулах нь түгээмэл болж, гэр бүлийн нэрийн бүтээгдэхүүн, гадаад улс руу экспортлох түвшний үйлдвэрүүд ч гарч ирлээ. Гэвч Нэгдэл ч, Хувьцаат компани ч, Хоршоо ч байхгүй болоод малын гаралтай түүхий эд түгээх ажлыг 100 жилийн өмнөх шиг ченжүүд хийж байна. Малын тоо өсөхийн хэрээр бэлчээрийг хамгаалахын тул хоёрхон айл ч хамт бууж чадахгүй, хот айл ч алга болоод “Ганц айл”-аар дахиад амьдарцгааж байна. Говийн “Ганц айл”-ын асуудлыг хэзээ, ямар нийгэмд шийдэж чадах юм бол?

Ном зүй

“Говь” төслийн зургууд.

小貫雅男、伊藤恵子制作 (1998)、ドキュメンタリー映画「四季 遊牧—ツェルゲルの人々 1992-1993」プロダクション大日

ОНУКИ Масао, ИТО Кэйко бүтээж, найруулсан баримтат кино “Four Seasons Nomadism – People living in Tselger from 1992-1993”. Production Dainichi (7 hours and 40 minutes).

今岡良子(1999)「ゴビ草原に探る共生のシステム — モンゴルの＜南＞の世界から」大月書店 [ИМАОКА Рёоко (1999) “Өмнөд”-ийн ертөнцөөс гарах арга – Монгол, Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэр хэсгийнхэн нэгдлээс гарч хоршоо байгуулсан тухай. Оцуки хэвлэлийн компани]

Youtube дээрх кино тойм:

No1. <https://www.youtube.com/watch?v=8ckpvZv3blc> (100 minutes)

No2. <https://www.youtube.com/watch?v=8WR0TCZd7O0> (100 minutes)

Анхаарал тавьсанд баярлалаа.

“Говь төсөл”-ийн гэрэл зурганд байгаа малчин ард маань
урт наслаж, удаан жаргаарай!